



БАЯНХОНГОР АЙМАГ
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 04 өдөр

Дугаар А/71

Хөхбүрд

Цэвэр, бохир усны шугам холбох ажилд
хяналтаар ажиллах ажлын хэсэг
байгуулах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 11 дүгээр зүйлийн 11.1 заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж байгаа төсөвт албан байгууллагуудын цэвэр, бохир усны шугам холбох ажилд хяналтаар ажиллах ажлыг зохион байгуулсугай.

2.Хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Г.Ганцоож (Засаг даргын орлогч)

Гишүүд:Ж.Болормаа (Ерөнхий боловсролын сургуулийн захирал)

Ж.Амартүвшин (Цэцэрлэгийн эрхлэгч)

С.Отгонжаргал (Эрүүл мэндийн төвийн дарга)

П.Сүхдалай (Соёлын өв хариуцсан ажилтан)

Ж.Тэгшээ (Иргэний төлөөлөл)

3.Ажлын явцыг нэг бүрчлэн хариуцлагатай чанартай хийгдэж буй эсэхэд хяналт тавьж, тэмдэглэл, илтгэх хуудас бичин танилцуулахыг ажлын хэсэгт даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (М.Жавзансүрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Г.ОРХОНТУУЛ



642301151